

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2024/12

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.XII	2023.XII	2024.XI	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2024 оны 3-р улирал	их наяд ₮, оны үнээр	56.1	46.5	56.1	-	-	-	5.0% ▲
Инфляц	хувь	9.0	7.9	8.1%	1.2% ▲	-	9.0% ▲	0.9% ▲ нэгж хувиар
Ажилгүйдлийн түвшин	хувь	6.1% 2024 оны УЗ	5.2% 2023 оны УЗ	5.8% 2024 оны У2	-	0.3% ▲ нэгж хувиар	-	0.9% ▲ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	-776.2	763	1,373	-2,149 ▲	-	-	-1,540 ▲
Ам.долларын ханш	төгрөг	3,417.9	3,421.2	3,412.7	5.16 ▲	-	-	-3.28 ▼
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	4,170.9	5,932	4,029.3	141 ▲	-	-	-1,761 ▼
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	79.5	66.7	74.0	-	-	-	12.8 ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	1,695.4	1,524.8	1,514.2	-	-	-	170.6 ▲
Төв банкны бодлогын хүү	хувь	10%	13%	10%	-	-	0%	-3%
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	5.5	4.9	4.9	10.83% ▲	-	-	11.81% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	5.05%	7.45%	5.78%	-0.72% Нэгж хувиар ▼	-	-	-2.39 нэгж хувиар ▼

ОНЦЛОХ СТАТИСТИК:

Гадаад валютын албан нөөц өсөв	Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 10.83%-р, өнгөрсөн жилийн мөн үеэс 11.81%-р тус тус өсөж, 5.5 тэрбум ам.долларт хүрэв.
--------------------------------	--

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
1072 хувьцааны ногдол ашиг 350,000 төгрөгийг 2025 онд 3 хувааж хуваарилна	2024/12/20	2024 онд “Эрдэнэс Тавантолгой” ХК 4.3 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж Монгол Улсын 3.4 сая иргэнд 1072 хувьцааны ногдол ашиг хуваарилахаар шийдвэр гарав.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

График


Нөлөөлөл

Инфляц




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 12 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 9.0 хувь, өмнөх сараас 1.2 хувиар өссөн байна. 2024 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүнсний барааны бүлгийн үнэ 8.7 хувиар, хүнсний бус барааны бүлгийн үнэ 9.1 хувиар, барааны бүлгийн үнэ 7.1 хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ 15.2 хувиар өсжээ.

Валютын ханш




Америк долларын ханш 2024 оны 12 дугаар сард 3,417.93 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.28 төгрөгөөр суларч, өмнөх сараас 5.16 төгрөгөөр чангарсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 10.83%-р, өнгөрсөн жилийн мөн үеэс 11.81%-р тус тус өсөж, 5.5 тэрбум ам.долларт хүрэв.

Улсын төсөв



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 31.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 7.0 (28.7%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 29.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 6.3 (27.0%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2024 онд 30.4 их наяд төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн тэнцэл 776.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

Гадаад худалдаа



Монгол Улс 2024 онд нийт 163 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 27.4 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 15.8 тэрбум ам.доллар, импорт 11.6 тэрбум ам.долларт хүрч, тэнцэл 4.2 тэрбум ам.долларын ашигтай гарчээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 3.0 (12.1%) тэрбум ам.доллар, экспорт 596.5 (3.9%) сая ам.доллар, импорт 2.4 (25.5%) тэрбум ам.доллороор тус тус өсөж, тэнцэл 1.8 (29.7%) тэрбум ам.доллороор буурсан байна.

Дэлхийн эдийн засагт

- 2024 онд Монгол Улсын эдийн засаг 5.9 хувь өснө. Эх үүсвэр: Азийн хөгжлийн банк
- Дэлхийн банкнаас Монгол Улсын эдийн засгийг 6.2% өснө гэж таамаглажээ.
- БНХАУ-ын эдийн засаг 2023 онд 5.2% өсөв.

Эх сурвалж:

1. [Статистикийн бюллетень, 12-р сар 2024 он, Үндэсний статистикийн хороо](#)
2. [Статистикийн бюллетень, 12-р сар 2024 он, Монголбанк](#)
3. www.1212.mn, www.monqolbank.mn